



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 457

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эм эмнэлэгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,000,000.00 (таван сая) төгрөгийн балансын үнэ 4,305,555.70 (дөрвөн сая гурван зуун таван мянга таван зуун тавин таван төгрөг далан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дуусч дахин үнэлгээ хийгдсэн Киа Спортэж маркийн 7321 УБЗ улсын дугаартай автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Хэнтий аймгийн өмчид (Хэнтий аймгийн ЗДТГ-т) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Г.Лхагвахатан, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хавсралтад заасан хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

